БАТЛАВ

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
.....Ц.АМАРТӨГС

2026 оны 02 дугаар сарын 27

" БАЯНЗАГ ОРЧМЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨӨЦ ДААЦЫН ҮНЭЛГЭЭГ МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГААР ГҮЙЦЭТГҮҮЛЭХ "АЖЛЫН ДААЛГАВАР

2026.02.27 Даланзадгад сум

№	Ажлын нэр, төрөл	Тайлбар
1.	Ажил гүйцэтгэх үндэслэл	**Өмнөговь аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх хэтийн зорилт, хэрэгжүүлэх төлөвлөгөө /2019-2029/** **Өмнөговь аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны "Өсөлттэй Өмнөговь" хөтөлбөр** **4**.1.5.6. Хэрмэн цав, Ёлын ам, Баянзаг, Шар цав, Хүрэн ханын хэц, Ханбогд хайрхны орчим аялал жуулчлалын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж, цогцолбор төслүүдийг төр- хувийн хэвшлийн түншлэлийн зарчмаар хэрэгжүүлж, аялагчдыг татах төв болгон хөгжүүлнэ. **Өмнөговь аймгийн 2026 оны хөгжлийн төлөвлөгөө** **196 дахь заалт**: Баянзаг орчмын аялал жуулчлал, байгаль орчны нөөц даацын үнэлгээг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх
2..	Ажлын зорилго	Баянзаг орчмын аялал жуулчлалын үйл ажиллагааны байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг харгалзан тухайн бүс нутгийн аялал жуулчлалын нөөц даац, хүлээн авах боломжит жуулчны тоо, ашиглалтын хязгаарыг шинжлэх ухааны үндэслэлтэй тодорхойлж, тогтвортой аялал жуулчлалын менежментийн зөвлөмж боловсруулахад оршино.
3.	Ажлын зорилтууд	• Судалгааны талбайн байгаль, экологийн өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлох; • Аялал жуулчлалын одоогийн ашиглалт, жуулчны урсгал, үйлчилгээний бүтэц, ачааллыг үнэлэх; • Экологийн, нийгэм-эдийн засгийн, дэд бүтцийн болон менежментийн нөөц даацыг тооцоолох; • Нөөц даац хэтрэх эрсдэлтэй бүс, цэгүүдийг тодорхойлох; • Аялал жуулчлалын бүсчлэл, зохицуулалтын хувилбар, нөөц даац нь хэтэрсэн бүс цэгүүдэд зохион байгуулах менежментийн зөвлөмж боловсруулах.
4.	Захиалагч	Өмнөговь аймгийн Засаг даргын Тамгын газар
5	Хэрэгжих нутаг дэвсгэр	Өмнөговь аймгийн Булган сумын Баянзаг, Төгрөгийн ширээ, Хавцгайтын хадны зураг зэрэг Өмнөговь аймгийн ИТХурлын 2018 оны 68 тоот

		тогтоолоор батлагдсан “Баянзагийн соёлын өвийн менежментийн төлөвлөгөө 2018-2024” -нд орсон бүс нутгууд, Булган сумын ИТХурлаар баталсан Баянзагийн орон нутгийн тусгай хамгаалалттай бүс нутагт орсон газар нутаг, бүсчлэлийн хүрээнд төслийг хэрэгжүүлнэ.
6	Гүйцэтгэх ажлын агуулга	**6.1. Бэлтгэл болон баримт бичгийн судалгаа** • Баянзаг орчмын бүс нутгийн аялал жуулчлал, байгаль орчны холбогдох бодлого, төлөвлөгөө, эрх зүйн баримт бичигт дүн шинжилгээ хийх; • Өмнө нь хийгдсэн судалгаа, үнэлгээ, газрын зураг, тайлан мэдээллийг цуглуулах, нэгтгэх; • Судалгааны талбайн хил хязгаар, хамрах хүрээг тодорхойлох. **6.2. Байгаль орчны өнөөгийн төлөв байдлын судалгаа** • Газрын гадарга, хөрс, геологийн тогтоц, элэгдэл эвдрэлийн байдлыг тодорхойлох; • Ургамал, амьтны аймаг, тэдгээрийн тархалт, эмзэг байдлыг судлах; • Биологийн олон янз байдал, биологийн төрөл зүйл, тэдгээрт учирч болох эрсдлийг тодорхойлох • Байгалийн доройтол, хүний үйл ажиллагааны нөлөөллийг тодорхойлох; • Авто замын элэгдэл, сүлжээ, авто замын сөрөг нөлөөлөл, цаашид хэрэгжүүлэх төлөвлөлтийг тодорхойлох • Үлэг гүрвэлийн олдворт газрын хамгаалал, бүсчлэлийг тодорхойлох • Эртний Цайны замын эвдрэл, өнөөгийн байдал, хамгааллын аргыг тодорхойлох • Гэр буудал, жуулчны баазуудын хоорондын зай, цаашид баримтлах журмыг тодорхойлох • Фото баримтжуулалт, GPS цэг тэмдэглэгээ хийх. **6.3. Аялал жуулчлалын ашиглалтын өнөөгийн байдлын үнэлгээ** • Жуулчны урсгалын тоо, улирлын хуваарилалт, ачааллыг тодорхойлох; • Жилд ирж байгаа жуулчдын тоон статистик, зорилтот зах зээлийг тодорхойлох • Жуулчдын зорчих маршрут, төвлөрсөн цэгүүдийг тодорхойлох; • Одоо байгаа аялал жуулчлалын дэд бүтэц (зам, авто зогсоол, ариун цэврийн байгууламж, мэдээллийн самбар гэх мэт)-ийн хүчин чадал, хүрэлцээг үнэлэх;

		• Аялал жуулчлалын үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагааны байршил, нөлөөллийг судлах. **6.4. Нөөц даацын тооцоо, үнэлгээ хийх** Дараах төрлийн нөөц даацыг шинжлэх ухааны аргачлал ашиглан тооцоолох: • Физик нөөц даац (нэг өдөр, нэг улиралд хүлээн авах боломжит жуулчны тоо) • Экологийн нөөц даац (байгаль орчинд сөрөг нөлөө үүсгэхгүй байх дээд хязгаар) • Нийгмийн нөөц даац (жуулчдын болон орон нутгийн иргэдийн тав тух, хүлээн авах боломж) • Дэд бүтцийн нөөц даац (зам, үйлчилгээ, байгууламжийн хүчин чадал) **6.5. Эрсдэлийн үнэлгээ хийх** • Хөрсний эвдрэл, доройтол • Ургамлын талхагдал • Хог хаягдал, бохирдол • Аялал жуулчлалын хэт ачааллын эрсдэлийг тодорхойлох; • Биологийн төрөл зүйлд үзүүлэх нөлөөллийг тодорхойлох • Археологийн дурсгалт газар, олдвор түүнд нөлөөлөх нөлөөлөл, хамгааллын арга, үйл ажиллагааг тодорхойлох • Палеонтологийн дурсгалт газар, олдвор түүнд нөлөөлөх нөлөөлөл, хамгааллын арга, үйл ажиллагааг тодорхойлох • Эрсдэлийн түвшинг ангилан зураглах. **6.6. Бүсчлэл, менежментийн санал боловсруулах** • Аялал жуулчлалын ашиглалтын бүсчлэл (өндөр ачаалалтай, хязгаарлалттай, хамгаалалтын бүс гэх мэт) боловсруулах; • Жуулчны урсгалыг зохицуулах санал боловсруулах; • Шинээр ашиглаж болох болон зөвхөн шинжлэх ухааны судалгаа явуулах онцгой бүс, аялагчид нэвтрэх бүс, орон нутгийн малчид иргэд, гар урчууд, аялал жуулчлал эрхлэгчид амьдрах, түр ашиглах, суурин байдлаар ашиглах газар, талбай, маршрутыг тодорхойлох; • Шинээр байгуулагдах жуулчны бааз, гэр буудлын хоорондын зай,олгогдох газар нутгийн хэмжээ, зам, цахилгаан шугам зэрэг дэд бүтэц хийгдэх талбай, газрыг тодорхойлох • Байгаль хамгаалал, ашиглалтын зохистой горим боловсруулах. **6.7. Газрын зураг, мэдээллийн сан боловсруулах** • Судалгааны үр дүнд үндэслэн GIS газрын зураг боловсруулах;

		• Нөөц даацын зураг; • Аялал жуулчлалын ашиглалтын зураг; • Эрсдэлийн зураг. **6.8. Тайлан, зөвлөмж боловсруулах** • Нөөц даацын үнэлгээний дэлгэрэнгүй тайлан боловсруулах; • Тогтвортой аялал жуулчлалын менежментийн зөвлөмж боловсруулах; • Хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах; • Захиалагч байгууллагад тайланг танилцуулах.
6.	Хүлээгдэж буй үр дүн	Баянзаг орчмын аялал жуулчлалын бүсийн байгаль орчны нөөц даацын үнэлгээг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тогтоож, тухайн бүс нутагт хүлээн авах боломжит жуулчны тоо, цаашид бий болох аялал жуулчлалын үйлчилгээний газрууд, бүтээн байгуулалтын тоо, хэмжээ, олгох газрын хэмжээ, ашиглалтын горим, зохицуулалтын хязгаарыг тодорхойлно. Үүний үндсэн дээр аялал жуулчлалыг байгаль орчинд сөрөг нөлөөгүй, тогтвортой хөгжүүлэх менежментийн зөвлөмж боловсруулж, нутгийн иргэдэд түшиглэсэн, шинжлэх ухаанд суурилсан тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх нөхцөл бүрдэнэ.
7.	Ажил гүйцэтгэх хугацаа	Гэрээнд заагдсан хугацаанд
8.	Гүйцэтгэгчид тавигдах шаардлага	• Байгаль орчин, аялал жуулчлалын судалгааны чиглэлээр мэргэшсэн, туршлагатай байх; • Шинжлэх ухааны академийн палеонтологи, археологийн хүрээлэнгийн эрдэмтэн, судлаачид, мэргэжилтний зөвлөмжийг хатуу мөрдөх, эсвэл мэргэжлийн судлаачдыг багтаа оролцуулах • Ижил төрлийн судалгаа, үнэлгээ гүйцэтгэсэн туршлагатай байх • Мэргэжлийн баг (экологич, аялал жуулчлалын мэргэжилтэн, судлаач) бүрдүүлсэн байх. • Төлөвлөлтийн эхэнд болон эцсийн танилцуулгын өмнө орон нутгийн төрийн байгууллага, аялал жуулчлал, археологи, палеонтологийн мэргэжлийн байгууллага, иргэдийн саналыг авч хэлэлцүүлж шаардлагатай заалт, төлөвлөлтийг тусгасан байх • Төлөвлөгөөг Аймгийн ИТХурлаар батлуулж зохих байгууллагуудад хэвлэлээр болон файлаар хүргүүлэх •

9.	Тайлан хүлээн авах	Гүйцэтгэгч нь судалгааны ажлын эцсийн тайланг хэвлэмэл 5 хувь, цахим хэлбэрээр (PDF болон эх файл) Өмнөговь аймгийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлнэ. Тайланг захиалагчийн байгуулсан ажлын хэсэг хүлээн авч, хянан үзэж, шаардлага хангасан тохиолдолд актаар баталгаажуулж хүлээн авна.

ХЯНАСАН:

НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Ө.МӨНХСАЙХАН

БОЛОВСРУУЛСАН:

НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН Э.БУЛГАН-ЭРДЭНЭ